



**БУЛГАН СУМЫН ТӨСВИЙН ЕРӨНХИЙЛӨН
ЗАХИРАГЧИЙН 2016 ОНЫ ЖИЛИЙН ТӨСВИЙН
ГҮЙЦЭТГЭЛ, САНХҮҮГИЙН НЭГТГЭСЭН ТАЙЛАН**

1

**Аудитын код: АРА-
2017/17/СТА-ТШЗ**

**Нэмэлт мэдээлэл авахыг
хүсвэл дараах хаягаар
харилцана уу:**

ТАБ-ын Тэргүүлэх аудитор
Утас: 70333141
Цахим хаяг:

Аудитын менежер:
Утас: 70332860
Цахим хаяг:

ТАБ-ын хаяг: Архангай
аймгийн Аудитын газар
Байршил: Эрдэнэбулган сум
Цахим хуудас:
www.audit.mn

Аудитын тайлан

Хавсралт 1: Агуулга

Хавсралт 2: Аудитын гэрчилгээ

Хавсралт 3: Аудит хийсэн санхүүгийн тайлан

Хавсралт 4: Менежмент захидал

Хавсралт 5: Төсвийн гүйцэтгэлийн тайлан

2017.03.23

1 Агуулга

1		0
2	Аудитын гэрчилгээ	2
3	Аудитын тайлан	4
3.1	Оршил	4
3.2	Аудит хийх үндэслэл, зорилго, талуудын хүлээх үүрэг, хариуцлага	4
3.3	Байгууллагын зорилго, үйл ажиллагаа, хууль, эрх зүйн орчин	5
3.4	Нягтлан бодох бүртгэлийн бодлого, үйл ажиллагаа болон дотоод хяналттай холбоотой хүчин зүйлсийн үнэлгээ	6
3.5	Төлөвлөлтийн шатанд тодорхойлсон эрсдэл, түүнийг үнэлсэн байдал	6
3.6	Материаллаг байдлын суурь сонгосон үндэслэл, тайлбар	6
3.7	Аудитын явцад хэрэгжүүлсэн горим сорил, түүний үр дүн	7
3.8	Аудитын явцад илрүүлсэн алдаа, зөрчилтэй асуудал, гаргасан шийдэл	7
3.8.1	Албан шаардлага өгсөн алдаа, зөрчилтэй асуудал	8
3.8.2	Сахилгын шийтгэл ногдуулахаар шилжүүлсэн алдаа, зөрчилтэй асуудал	8
3.9	Дараагийн аудитаар авч үзэх буюу анхаарал татахуйц бусад чухал асуудал	8
3.10	Төсвийн гүйцэтгэлийн талаарх тайлбар, тодруулга	8
3.11	Шилэн дансны мэдээлэл	9
3.12	Өмнөх зөвлөмжийн хэрэгжилтийн талаарх тайлбар, тодруулга	9
3.13	Санал дүгнэлтийн хэлбэр, үндэслэл	9
4	Менежментийн захидал	11
4.1	Орлого	12
5	Аудит хийсэн санхүүгийн нэгтгэсэн тайлан, төсвийн гүйцэтгэл	13
5.1	Аудит хийсэн санхүүгийн байдлын тайлан	13
5.2	Аудит хийсэн санхүүгийн үр дүнгийн тайлан	15
5.3	Аудит хийсэн мөнгөн гүйлгээний тайлан	18
5.4	Аудит хийсэн цэвэр хөрөнгө/өмчийн/ тайлан	21
5.5	Аудит хийсэн төсвийн гүйцэтгэлийн тайлан	22
5.6	Аудит хийсэн нэмэлт төсвийн гүйцэтгэлийн тайлан	24
5.7	Аудит хийсэн орон нутгийн орлогын тайлан	25

2 Аудитын гэрчилгээ

 ҮНДЭСНИЙ АУДИТЫН ГАЗРЫН ХАРЬАА АРХАНГАЙ АЙМГИЙН АУДИТЫН ГАЗАР 65130 Цэцэрлэг, Архангай аймаг Утас/Факс: (976) 7033-3141 E-mail: arkhangai@audit.gov.mn	БУЛГАН СУМЫН ТӨСВИЙН ЕРӨНХИЙЛӨН ЗАХИРАГЧИЙН ҮҮРГИЙГ ТҮР ОРЛОН ГҮЙЦЭТГЭГЧ Г.ГАНБАЯР ТАНАА
2017.05.22 № 97 танай _____-ны № _____-т	
Аудитын гэрчилгээ	
Булган сумын төсвийн Ерөнхийлөн захирагчийн 2016 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх дуусвар болсон, аккруэл сууриар бэлтгэгдсэн, жилийн эцсийн санхүүгийн нэгтгэсэн тайланд Төрийн аудитын тухай хуулийн 15.2.1-д заасан бүрэн эрхийн дагуу Архангай аймгийн Аудитын газраас аудит хийв. Булган сумын төсвийн Ерөнхийлөч захирагч нь тайлант хугацааны санхүүгийн тайланг холбогдох хууль, Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандарт, түүнтэй нийцүүлэн Сангийн сайдын баталсан заавар, журмуудын дагуу үнэн зөв бэлтгэж, тайлагнах үүрэг, хариуцлага хүлээнэ. Төрийн аудитын байгууллага нь Төсвийн захирагчийн 2016 оны жилийн эцсийн санхүүгийн тайланд Аудитын олон улсын стандартын дагуу аудит хийж, санал дүгнэлт өгөх үүрэг, хариуцлага хүлээнэ. Санал дүгнэлтийн үндэслэл Төрийн аудитын байгууллага аудит хийхдээ Аудитын олон улсын стандарт, түүнд нийцүүлэн Монгол Улсын Ерөнхий аудиторын баталсан Санхүүгийн тайлангийн аудитын журмын дагуу гүйцэтгэсэн. Эдгээр стандарт, журам нь санхүүгийн тайлан материалыг буруу илэрхийллээс ангид эсэх талаар үндэслэлтэй баталгаа олж авах зорилгоор аудитыг төлөвлөж, гүйцэтгэхийг шаарддаг. Аудитаар Булган сумын төсвийн Ерөнхийлөн захирагчийн 2016 оны жилийн эцсийн санхүүгийн тайлан дахь үлдэгдэл, ажил гүйлгээний дүн хэмжээ болон илчлэл тодруулга, тус байгууллагад мөрдөж байгаа нягтлан бодох бүртгэлийн бодлого, бүртгэлийн хөтлөлт, програм хангамж, дотоод хяналтын систем, гол хууль тогтоомжуудын мөрдөлтийг болон удирдлагын хийсэн томоохон тооцооллыг шалгаж, аудитын санал дүгнэлтийг дэмжих нотлох зүйлсийг хангалттай цуглуулсан. Төсөв захирагч нь Төсвийн тухай хуулийн 41.2 <i>“Бүх шатны төсвийн захирагч төсвийн хэрэгжилтийн талаар дараах үүрэг хүлээнэ”, 41.2.1 “хуулийн дагуу улс, орон нутгийн төсөвт оруулах болон тухайн төсвийн байгууллагын өөрийн үйл ажиллагааны орлогыг бүрэн төвлөрүүлэх”, Сангийн Сайдын 2012 оны 290 дүгээр тушаалын 5.1-т “...хөрөнгө оруулалтаар хийгдсэн ажил нь төрийн, эсхүл орон нутгийн өмчид заавал бүртгэгдэх бөгөөд барилга байгууламж, худалдан авсан тоног төхөөрөмжийг ашиглалтанд хүлээн авсан эцсийн гүйцэтгэлийн дүнгээр тухайн төсөвт байгууллагын тайлан балансанд бүртгэнэ...”</i> гэсэн хууль, журмын заалтуудыг тус тус зөрчиж 70,042,896 төгрөгийн алдаа зөрчлийг гаргасан байна.Зөрчлийг дурьдвал:	

- Сумын 2016 оны Орон нутгийн хөгжлийн сангийн хөрөнгөөр хийгдсэн гудамжны гэрэлтүүлэг 18,000,000 төгрөгийн өртөг бүхий, сумын хүндэтгэлийн хаалга 19,985,818 төгрөгийн өртөг бүхий хөрөнгүүдийг Засаг даргын тамгын газрын 2016 санхүүгийн тайланд орлого авч бүртгэж тайлагнаагүй орхигдуулсан
- Мөн орон нутгийн төсвийн орлого 6 нэр төрөл дээр 32,057,078 төгрөгөөр тасарсан байна.

Дээрх зөрчлүүд нь санхүүгийн тайлангийн “*оршин байх, үнэн зөв байдал*” батламж мэдэгдлийг хангахгүй байна.

Бидний хийсэн аудит санхүүгийн тайланд санал дүгнэлт өгөх хангалттай бөгөөд зохистой үндэслэлийг бүрдүүлсэн.

Хязгаарлалттай санал дүгнэлт

Дээрх алдаа зөрчлийг эс тооцвол Булган сумын төсвийн Ерөнхийлөн захирагчийн 2016 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн байдал, санхүүгийн үр дүн, мөнгөн гүйлгээ, өмчийн өөрчлөлтийн болон төсвийн гүйцэтгэлийн тайлан, илчлэл тодруулгад тайлагнасан үлдэгдэл, ажил гүйлгээнүүд холбогдох хууль, УСНББОУС, түүнд нийцүүлэн Сангийн сайдын баталсан заавар, журмуудын дагуу материаллаг алдаагүй, үнэн зөв, шударга илэрхийлэгдсэн байна.

ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР



ДУЛАМБАЯР

3 Аудитын тайлан

3.1 Оршил

Булган сумын Төсвийн Ерөнхийлөн захирагчийн үүргийг түр орлон гүйцэтгэгч Ганбаатар овогтой Ганбаярт танилцуулж байна.

Энэхүү тайланд үйлчлүүлэгчийн санхүү, нягтлан бодох бүртгэл, дотоод хяналтын системд хийсэн үнэлгээний тойм, аудитын явцад илрүүлсэн гол зүйлс, гаргасан шийдлүүд, анхаарал хандуулахуйц залруулаагүй материаллаг биш алдаа зөрчлийн талаарх тайлбар, тодруулга зэрэг аудитын үр дүнгийн талаарх тайлбар, тодруулга, аудитын санал дүгнэлтийн хэлбэр, үндэслэлийн талаар тус тус хураангуйлан тэмдэглэв.

Дараагийн заалтад аудит хийсэн санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийн тайланг батлагдсан ангилал, үзүүлэлтээр бэлтгэж, оруулав.

3.2 Аудит хийх үндэслэл, зорилго, талуудын хүлээх үүрэг, хариуцлага

Бид Төрийн аудитын тухай хуулийн 15.2.1-д заасан бүрэн эрхийн хүрээнд энэ хуулийн 18.2, Төсвийн тухай хуулийн 8.9.2 дахь заалтыг хэрэгжүүлэх зорилгоор Булган сумын Засаг даргын 2016 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон жилийн эцсийн санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд санхүүгийн тайлангийн аудит хийлээ.

Аудитыг Төсвийн тухай, Төрийн аудитын тухай, Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулиуд болон холбогдох бусад хууль, тогтоомжийн хүрээнд Аудитын олон улсын стандартын зарчмуудад нийцүүлэн төлөвлөлтийн шатанд боловсруулсан төлөвлөгөө, хөтөлбөрийн дагуу явуулав.

Булган сумын Засаг даргын 2016 оны нэгтгэсэн санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэл Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль болон Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн Олон улсын стандарт, түүнд нийцүүлэн гаргасан төр, төсвийн байгууллагын нягтлан бодох бүртгэлийн бодлого, заавар, журмын дагуу үнэн зөв, шударга илэрхийлэгдсэн эсэхэд дүгнэлт өгөх нь энэхүү аудитын зорилт байв.

Төсвийн захирагч санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийн тайлангаа Төсвийн тухай хууль болон Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн Олон улсын стандарт, түүнд нийцүүлэн баталсан төсвийн байгууллагын нягтлан бодох бүртгэлийн бодлого, журмын дагуу үнэн зөв, бодитой бэлтгэх үүрэгтэй.

Харин тухайн санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг дээрх хууль болон бодлого, журмын дагуу материаллаг алдаагүй, үнэн зөв, шударга илэрхийлсэн эсэхэд санал дүгнэлт өгөх нь Төрийн аудитын байгууллагын үүрэг юм.

Аудитыг 2017.03.05 - наас 2017.03.22 – ны хооронд хийж, аудитын тайланг 2017.03.23 - нд эцэслэн баталгаажуулж, үйлчлүүлэгчийн удирдлагад хүргүүлэхээр төлөвлөн, аймгийн Аудитын газрын Шинжээч Ж.Мөнгөншагай хариуцаж хэрэгжүүлэв.

Булган сумын Засаг даргын 2016 оны жилийн эцсийн нэгтгэсэн санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийн тайланг 2017.03.03 - нд төрийн аудитын байгууллагад 51 тоот албан бичгээр ирүүлсэн байна.

3.3 БАЙГУУЛЛАГЫН ЗОРИЛГО, ҮЙЛ АЖИЛЛАГАА, ХУУЛЬ, ЭРХ ЗҮЙН ОРЧИН

Бид Аудитын олон стандартад зааснаар үйлчлүүлэгч байгууллагын үйл ажиллагаа, гадаад дотоод орчны талаар төлөвлөсөн бодлого, журмын дагуу шаардлагатай гэж үзсэн хэмжээнд судалж, тэдгээрийн үр дүнг аудитад ашигласан.

Булган сумын Засаг дарга “Сумын Иргэдийн Төлөөлөгчдийн хурал, Засаг дарга, байгууллага иргэдийн хэвийн ажиллах нөхцөлийг баталгаатай ханган төрийн үйлчилгээг чанартай, шуурхай хүргэж орон нутагтаа сайн сайхан, эрүүл аюулгүй амьдрах орчин нөхцөлийг бүрдүүлэн улс төрийн аливаа нөлөөлөлд автахгүйгээр иргэддээ үнэнч шудрага үйлчлэн үйл ажиллагаагаараа үргэлж манлайлсан аймгийн тэргүүний сум байхад оршино.” эрхэм зорилгын дор Аймгийн Засаг даргын эрхлэх асуудлын хүрээнд дараах үйл ажиллагааг эрхлэн гүйцэтгэж байна. Үүнд:

Булган сумын Засаг дарга дээрх хуулиар тогтоосон чиг үүрэг, үйл ажиллагааны хүрээнд өөрийн эрхлэх асуудал, үйл ажиллагааныхаа чиглэл, цар хүрээг дараах байдлаар тодорхойлж баталгаажуулжээ. Үүнд:

Тайлант хугацаанд Булган сумын Засаг дарга “Төрийн үйлчилгээний чанар, хүртээмжийг дээшлүүлж, иргэд хүнд сурталгүй аливаа чирэгдэлгүй, хурдан шуурхай үйлчлэх явдлыг хэвшүүлж, эдийн засаг нийгмийн бусад хөтөлбөрүүдтэй нягт уялдсан цэгцтэй, уян хатан бөгөөд үр ашигтай үйлчилгээг бий болгоно.” гэсэн зорилтыг дэвшүүлэн ажиллажээ.

Булган сумын Засаг даргын удирдлага төсвийн шууд захирагчийн хувьд дараах хууль болон УСНББОУС, түүнд нийцүүлэн баталсан төсвийн байгууллагын Нягтлан бодох бүртгэлийн бодлого, журмын хүрээнд төсөв, санхүү, нягтлан бодох бүртгэлийн үйл ажиллагааг эрхлэн гүйцэтгэж байна. Үүнд : Төрийн болон орон нутгийн өмчийн тухай, Нягтлан бодох бүртгэлийн тухай, Монгол Улсын Төсвийн тухай хууль болон бусад холбогдох хуулиуд, Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн Олон улсын стандарт /УСНББОУС/, Сангийн сайдын 2006 оны 388, 2008 оны 352 дугаар тушаалаар баталсан “Төсөвт байгууллагад мөрдөх нягтлан бодох бүртгэлийн дансны заавар, санхүүгийн тайлан, тодруулгын маягт, санхүүгийн тайлан бэлтгэж гаргах аргачлал, “Эдийн засгийн ангилал батлах тухай” Сангийн сайдын 2014 оны 5 дугаар тушаалаар баталсан Төсвийн орлогын эдийн засгийн дэлгэрэнгүй ангилал, Төсвийн зарлагын эдийн засгийн дэлгэрэнгүй ангилал, Төсвийн эх үүсвэрийн ангилал, САГ/2017/42/СТА-ТШЗ Төсвийн бусад мэдээллийн болон Балансын дансны ангилал, “Тушаалд өөрчлөлт оруулах тухай” 2014 оны 55 дугаар тушаалаар Төсвийн зарлагын эдийн засгийн ангиллыг ашиглах заавар, “Төсвийн ангилал шинэчлэн батлах тухай” 2015 оны 7 дугаар тушаалаар баталсан “Төсвийн орлогын эдийн засгийн ангилал, Төсвийн зарлагын эдийн засгийн ангилал, Төсвийн зарлагын хөтөлбөрийн ангилал, Зардлын зориулалт, арга хэмжээний ангилал”, “Журам шинэчлэн батлах тухай” 2015 оны “Төсвийн ерөнхийлөн захирагчийн болон Засгийн газрын санхүүгийн нэгтгэсэн тайлан, тодруулга бэлтгэх журам”-ыг 1 дүгээр хавсралт, “Санхүүгийн нэгтгэсэн тайлан, тодруулгын маягт”-ыг 2 дугаар хавсралтыг 341 дүгээр тушаалаар батлан тус бүр мөрдөн ашиглаж байна. Түүнчлэн тус байгууллагын үйл ажиллагааны онцлогтой холбоотой холбогдох бусад хууль тогтоомжууд, тэдгээрийн хэрэгжилтийг

хангуулахаар гаргасан Засгийн газрын тогтоол, Сангийн сайдын тушаалаар баталсан дүрэм, журам, заавар, аргачлалыг үйл ажиллагаандаа мөрдөн ажиллаж байна.

3.4 Нягтлан бодох бүртгэлийн бодлого, үйл ажиллагаа болон дотоод хяналттай холбоотой хүчин зүйлсийн үнэлгээ

Бид санхүүгийн нэгтгэсэн тайланд материаллаг алдаа байхгүй гэдгийг нягтлах үүднээс үйлчлүүлэгчийн нягтлан бодох бүртгэлийн бодлого, үйл ажиллагаа болон дотоод хяналтыг шаардлагатай гэж үзсэн хэмжээгээр дахин хянасан. Энэ нь материаллаг алдаа гарахаас хамгаалах ёстой гол бодлого, хяналтуудыг тодруулах, судлах зорилготой юм.

Булган сумын Засаг дарга санхүүгийн тайлан, тодруулга, төсвийн гүйцэтгэлийн тайлан бэлтгэх, ажил гүйлгээг бүртгэх, хянах үйл ажиллагаанд санхүүгийн “Plastic” програм хангамж ашиглажээ.

3.5 Төлөвлөлтийн шатанд тодорхойлсон эрсдэл, түүнийг үнэлсэн байдал

Булган сумын Засаг даргын бэлтгэсэн санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэл нь материаллаг хэмжээний алдаатай илэрхийлэгдээгүй гэсэн үндэслэлтэй нотолгоо олж авахын тулд санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийн тайлантай холбоотой уламжлалт болон хяналтын эрсдэлийг илрүүлэх, үнэлэх үе шатны ажлын талаар товч толилуулъя.

Аудитыг төлөвлөх үе шатанд байгууллага, түүний гадаад, дотоод орчны талаарх цуглуулсан мэдээлэл, ойлголтод үндэслэн эрсдэлийн үнэлгээний горим хэрэгжүүлэн 27 эрсдэлтэй асуудал тодорхойлон, тэдгээрийг ТАБ-СТА-Б-2.6 маягтад нэгтгэж, баримтжуулав.

Дээрх эрсдэлтэй асуудал тус бүрийг дахин нарийвчлан үнэлэхэд 3 асуудал эрсдэл дунд гэсэн үр дүн гарлаа.

Эрсдэлийн ерөнхий үнэлгээг ТАБ-СТА-Б-4.3 маягтад нэгтгэн баримтжуулсан бөгөөд нийт эрсдэлийн үнэлгээний түвшин 9 байна.

Эрсдэлийн үнэлгээний дүнд үндэслэн эрсдэл дунд буюу зайлшгүй шалгах эрсдэлтэй 2 асуудлыг аудитын чиглэл тус бүрээр нэгтгэж, тэдгээрийг сорих – шалгах аудитын горим сорил, шалгуур үзүүлэлт, нотлох зүйл цуглуулах арга замыг холбогдох маягтаар баримтжуулан баталгаажуулсан болно.

3.6 МАТЕРИАЛЛАГ БАЙДЛЫН СУУРЬ СОНГОСОН ҮНДЭСЛЭЛ, ТАЙЛБАР

Аудитыг төлөвлөх болон гүйцэтгэх үеийн материаллаг байдлыг Аудитын олон улсын стандарт 320-ын дагуу тодорхойлсон бөгөөд материаллаг байдлын суурь үзүүлэлтээр санхүүгийн үр дүнгийн тайлангийн Нийт зардал-ийг сонгов.

Шалтгаан нь: Төсвийн тухай хуулийн дагуу орон нутгийн төсвөөс санхүүждэг, 100 хувь төсөвт байгууллага тул материаллаг байдлын суурийг тооцохдоо санхүүгийн үр дүнгийн тайлангийн нийт зардлаас 1 хувиар тооцоход 20.9 сая төгрөг байна.

3.7 Аудитын явцад хэрэгжүүлсэн горим сорил, түүний үр дүн

Аудитыг төлөвлөх шатанд тогтоосон эрсдэл тус бүрд хэрэгжүүлэхээр төлөвлөсөн горим сорилын хэрэгжилт, гол үр дүнгийн талаар горим сорилуудыг хэрэгжүүлэн, илэрсэн алдаа зөрчил, залруулагдсан алдааг СТАУС программд ТАБ-СТА-В-3.1, ТАБ-СТА-В-4.1, ТАБ-СТА-В-4.2, ТАБ-СТА-В-4.3, ТАБ-СТА-В-4.4, ТАБ-СТА-В-4.5 маягтуудаар нэгтгэн баримтжуулан хавсаргасан болно.

Харин санхүүгийн тайлан, тодруулга дахь залруулаагүй буруу илэрхийлэл буюу алдаа зөрчилтэй асуудалд дүн шинжилгээ хийж, алдаа зөрчлийг дараах байдлаар ангилав.

(Сая төгрөгөөр)

№	Буруу илэрхийлэл буюу алдаа зөрчлийг ангилсан байдал	Тоо	Дүн	Тайлбар
1	Зөвлөмж болгосон асуудал	1	32.0	
2	Төлбөрийн акт тогтоосон	0	0	
3	Албан шаардлага өгсөн	1	38.0	
4	Сахилгын шийтгэл ногдуулахаар шилжүүлсэн	0	0	
5	Хууль хяналтын байгууллагад асуудлыг шилжүүлсэн	0	0	
	Дүн	2	65.1	

Дээрх зөрчилтэй асуудлын дэлгэрэнгүй жагсаалтыг ТАБ-СТА-В-4.6.1-5 маягтад нэгтгэн баримтжуулав.

3.8 Аудитын явцад илрүүлсэн алдаа, зөрчилтэй асуудал, гаргасан шийдэл

- Булган сумын ИТХ-н төлөөлөгчдийн 2016.11.14-ны өдрийн 05 тоот тогтоолоор сумын орон нутгийн төсвийн орлогыг 13 нэр төрлийн **207.3** сая төгрөгөөр тодотгон баталсан байна. Тайлангийн хугацаанд Төсвийн орлого нийт дүнгээрээ **219.3** төгрөгийн гүйцэтгэлтэй **12.0** сая төгрөгөөр давж биелсэн хэдий ч зургаан нэр төрлийн орлого **32.0** сая төгрөгөөр тасарсан байна.

Энэ нь Төсвийн тухай хуулийн 41.2 “Бүх шатны төсвийн захирагч төсвийн хэрэгжилтийн талаар дараах үүрэг хүлээнэ”, 41.2.1 “хуулийн дагуу улс, орон нутгийн төсөвт оруулах болон тухайн төсвийн байгууллагын өөрийн үйл ажиллагааны орлогыг бүрэн төвлөрүүлэх” гэсэн заалтыг зөрчсөн байна.

Шийдвэрлэсэн нь : Орлогын төлөвлөгөөг жигд ханган биелүүлэх талаар зөвлөмж хүргүүлсэн бөгөөд энэ талаар тайлангийн 4 дүгээр бүлгийн Менежементийн захидалд дурьдагдах болно.

Харин бусад материаллаг буруу илэрхийлэл буюу алдаа зөрчилтэй асуудлыг хэрхэн шийдвэрлэсэн байдлаар дараах заалтад ангилан харуулав.

3.8.1 Албан шаардлага өгсөн алдаа, зөрчилтэй асуудал

Сумын 2016 оны Орон нутгийн хөгжлийн сангийн хөрөнгөөр хийгдсэн **18.0** сая төгрөгийн өртөг бүхий гудамжны гэрэлтүүлэг, **19.9** сая төгрөгийн өртөг бүхий сумын хүндэтгэлийн хаалга зэрэг нийт **38.0** сая төгрөгийн хөрөнгүүдийг Засаг даргын тамгын газрын 2016 санхүүгийн тайланд орлого авч бүртгэж тайлагнаагүй орхигдуулжээ.

Энэ нь Сангийн Сайдын 2012 оны 290 дүгээр тушаалын 5.1-т "...хөрөнгө оруулалтаар хийгдсэн ажил нь төрийн, эсхүл орон нутгийн өмчид заавал бүртгэгдэх бөгөөд барилга байгууламж, худалдан авсан тоног төхөөрөмжийг ашиглалтанд хүлээн авсан эцсийн гүйцэтгэлийн дүнгээр тухайн төсөвт байгууллагын тайлан балансанд бүртгэнэ ..." гэсэн заалтыг зөрчсөн байна.

Шийдвэрлэсэн нь: Бүртгэл тайланд тусгаагүй орхигдуулсан хөрөнгийг бүртгэлд тусгуулах тухай албан шаардлага хүргүүлжээ.

3.8.2 Сахилгын шийтгэл ногдуулахаар шилжүүлсэн алдаа, зөрчилтэй асуудал

Дээрх алдаа зөрчлүүд нь Булган сумын Төсвийн Ерөнхийлөн захирагчийн 2016 оны жилийн төсвийн гүйцэтгэл, санхүүгийн нэгтгэсэн тайлангийн дүгнэлтийг хязгаарлахад хүргэж байгаа тул Төрийн аудитын тухай хуулийн 28.2 дахь заалтын дагуу буруутай албан хаагчидад сахилгын шийтгэл ногдуулах албан шаардлагыг хүргүүлжээ.

3.9 ДАРААГИЙН АУДИТААР АВЧ ҮЗЭХ БУЮУ АНХААРАЛ ТАТАХУЙЦ БУСАД ЧУХАЛ АСУУДАЛ

Төсвийн тухай хуулийн 41.2.1 дахь заалтын дагуу улс, орон нутгийн төсөвт оруулах болон тухайн төсвийн байгууллагын өөрийн үйл ажиллагааны орлогыг бүрэн төвлөрүүлэх" гэсэн заалтын хэрэгжилтийг Орон нутгийн орлогын гүйцэтгэлийг нэр төрөл бүрээр нь тулган шалгана

3.10 Төсвийн гүйцэтгэлийн талаарх тайлбар, тодруулга

Төсвийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.1-д заасны дагуу төсвийг төлөвлөх, хэрэгжүүлэх, тайлагнахад эрх бүхий байгууллага, төсвийн захирагч нь энэ хуулийн 5 дугаар зүйлийн 5.1-д заасан төсвийн зарчмыг мөрдлөг болгож, хэрэгжүүлэх үүрэгтэй.

Төрийн аудитын байгууллага санхүүгийн тайлангийн аудитаар батлагдсан төсвийн гүйцэтгэлийг зохих журмын дагуу зохион байгуулж, үнэн зөв, тайлагнасан эсэхэд үнэлэлт өгөхийг зорьдог.

Булган сумын Засаг дарга өөрийн чиг үүргээ хэрэгжүүлэхтэй нь холбоотой хөтөлбөр, арга хэмжээнд зориулан сумын Иргэдийн төлөөлөгчдийн хурлын 2016.11.14-ны өдрийн 05 тоот тогтоолоор урсгал зардалд **1384.3** сая төгрөгийн, хөрөнгийн зардалд **256.7** сая төгрөгийн нийт **1641.0** сая төгрөгийн төсөв батлуулан, гүйцэтгэлээр **1463.1** сая төгрөгийн зардал гарсан байна.

Батлагдсан төсөв, гүйцэтгэлийн талаарх мэдээллийг дор нэгтгэн харуулав.

/Сая төгрөгөөр/

№	Үзүүлэлт	Төлөвлөгөө	Гүйцэтгэл	Хувь	Зөрүү
1	Нийт зарлага ба цэвэр зээлийн дүн	1641.0	1463.1	89.1%	177.9
1.1	Урсгал зардал	1384.3	1277.6	92.3%	106.7
1.2	Хөрөнгийн зардал	256.7	185.5	72.3%	71.2

Тайлант оны төсвийн гүйцэтгэл 89.1 хувьтай байна. Төлөвлөгөө гүйцэтгэлийн зөрүү **177.8** сая төгрөг байна. Энэ нь орон нутгийн хөгжлийн сангийн үлдэгдэл **52.1** сая төгрөг, сум хөгжүүлэх сангийн орлого бүрдээгүйгээс төлөвлөгөө гүйцэтгэлийн зөрүү **84.6** сая төгрөг, төсөвт байгууллагуудын төвлөрүүлэх шилжүүлэг **41.1** сая төгрөг тус тус байна.

Сумын Иргэдийн төлөөлөгчдийн хурлын 2016.11.14-ны өдрийн 05 тоот тогтоолоор сум хөгжүүлэх сангийн орлогыг **90.5** сая төгрөгөөр, гүйцэтгэлийг **89.2** сая төгрөгөөр баталсан боловч орлогын гүйцэтгэл хангалтгүйгээс төлөвлөгөөний дагуу иргэд, аж ахуй нэгжид сангаас олгох зээл гарах боломжгүй байсан байна.

Орон нутгийн төсвийн орлогын төлөвлөгөө **207.3** сая төгрөгөөр батлагдаж **219.3** сая төгрөгийн гүйцэтгэлтэй байна. Төсвийн орлого 7 нэр төрөл дээр **44.0** сая төгрөгөөр давж биелсэн бол 6 нэр төрлийн орлого **32.0** сая төгрөгөөр тасарч 13 нэр төрлийн орлого нийт дүнгээрээ **12.0** сая төгрөгөөр давсан байна.

Тайлант хугацаанд Төсвийн тухай хуулийн 47 дугаар зүйлд заасан нэмэлт төсвийн дансаар нийт **9.8** сая төгрөг зарцуулагдсан байна.

Дээрх зардлыг санхүүжүүлсэн эх үүсвэрийг ангилал тус бүрээр нэмэлт төсвийн тайлангаар баримтжуулан баталгаажуулав.

3.11 Шилэн дансны мэдээлэл

Булган сумын Засаг дарга Шилэн дансны тухай хуулийн 6 дугаар зүйлд заасан мэдээллийг өөрийн цахим хуудсаар дамжуулан тухай бүр ил тод мэдээлж байх үүрэгтэй.

Шилэн дансны хуультай холбоотой байж болох мэдээ, мэдээллийг хуулийн дагуу, цаг тухай бүрд нь шилэн дансны сайтад байршуулсан байна.

3.12 Өмнөх зөвлөмжийн хэрэгжилтийн талаарх тайлбар, тодруулга

Аймгийн Аудитын газраас өмнөх онд орон нутгийн төсвийн орлогын гүйцэтгэлийг нэр төрөл бүр дээр жигд ханган биелүүлж ажиллах талаар зөвлөмж хүргүүлсэн боловч хэрэгжилт хангалтгүйгээс энэ асуудал нь 2016 оны жилийн эцсийн санхүүгийн тайланд дахин давтагдан гарсан байна.

3.13 Санал дүгнэлтийн хэлбэр, үндэслэл

Бид Булган сумын Засаг даргын 2016 оны жилийн эцсийн санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийн тайланд аудит хийж, баталгаажуулах ажлыг Аудитын Олон улсын стандартын дагуу, Монгол Улсын холбогдох хууль тогтоомжид нийцүүлэн гүйцэтгэсэн.

Тайлангийн 3.8-д дурьдсан алдаа зөрчлийг эс тооцвол Булган сумын Засаг даргын 2016 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх нэгтгэсэн санхүүгийн байдал, санхүүгийн үр дүн, мөнгөн гүйлгээ, өмчийн өөрчлөлтийн болон бусад илчлэл тодруулгад тайлагнасан үлдэгдэл, ажил гүйлгээнүүдээ холбогдох хууль, УСНББОУС, түүнд нийцүүлэн Сангийн сайдын баталсан заавар, журмуудын дагуу материаллаг байдлын хувьд алдаагүй, үнэн зөв, шударга илэрхийлсэн байна гэж үзэж **“Хязгаарлалттай”** санал дүгнэлт гаргалаа.

Аудитын явцад илэрсэн залруулаагүй буруу илэрхийлэл буюу алдаа зөрчлийг энэ тайлангийн 3.8-д нэгтгэн тусгасан бөгөөд эдгээр буруу илэрхийлэл буюу алдаа, зөрчлийн дүн материаллаг байдлын түвшингээс их байгаа тул аудитын санал дүгнэлтийг хязгаарлах үндэслэлтэй байна. / Аудитын санал дүгнэлтийг энэ тайлангийн 1 дүгээр хэсэгт үзүүлэв. /

Аудитлагдсан санхүүгийн тайлан /... хуудас/-ыг хавсаргав.

ҮНДЭСНИЙ АУДИТЫН ГАЗРЫН ХАРЪЯА
АРХАНГАЙ АЙМГИЙН АУДИТЫН ГАЗАР

2017 оны 3 дугаар сар

4 МЕНЕЖМЕНТИЙН ЗАХИДАЛ

Төрийн аудитын байгууллага санхүүгийн тайлангийн аудит бүрийн төгсгөлд аудитаар илрүүлсэн зүйлсийг нэгтгэсэн менежментийн захидлыг үйлчлүүлэгч, түүний удирдлагад зориулж бэлтгэдэг бөгөөд түүнд санхүү, нягтлан бодох бүртгэл, тайлагналийн бодлого, үйл ажиллагаа, дотоод хяналтыг сайжруулах зөвлөмжийг тусгадаг.

Энэхүү менежментийн захидлын агуулга Аудитын олон улсын стандарт болон аудитын дүн, дүгнэлтээс урган гарсан болно. Санхүүгийн тайлан, бусад илчлэл тодруулгын талаар санал дүгнэлт гаргахад бидний бодлого, горим зориулагдсан.

Энэ нь Булган сумын Засаг даргын нягтлан бодох бүртгэлийн бодлого, горимыг зөвхөн аудитыг үр нөлөөтэй гүйцэтгэхэд шаардагдах цар хүрээнд дахин хянасан бөгөөд оршиж буй бүх сул талыг гаргаж ирэх боломжгүй юм.

Тиймээс аудитын тайланд тусгасан зөвлөмж нь аудит хийх үеийн нөхцөл байдлын талаархи бидний үнэлэлт, дүгнэлтийг илэрхийлж байгаа болно.

Харин эдгээр зөвлөмжийг та бидний хамтын ажиллагааны байр сууринаас гаргасан бөгөөд аудитаар өгсөн зөвлөмжийг хүлээн авч, хэрэгжүүлэх нь танай үүрэг хариуцлага юм.

Аудитын явцад бидэнтэй хамтран ажилласан холбогдох ажилтнуудад талархал илэрхийлье

Менежментийн захидалд дурьдсан цаашид санхүүгийн тайланд шууд бөгөөд материаллаг хэмжээгээр нөлөөлж болзошгүй тул анхаарвал зохих асуудлыг тэргүүлэх ач холбогдолтойгоос нь эхлэн эрэмбэлэн үзүүлэв.

4.1 Орлогын бүрдүүлэлтийн талаар:

Илрүүлэлт

Булган сумын ИТХ-н төлөөлөгчдийн 2016.11.14-ны өдрийн 05 тоот тогтоолоор сумын орон нутгийн төсвийн орлогыг **207.3** сая төгрөгөөр тодотгон баталсан байна. Тайлангийн хугацаанд Төсвийн орлого нийт дүнгээрээ **12.0** сая төгрөгөөр давж биелсэн хэдий ч зургаан нэр төрлийн орлого **32.0** сая төгрөгөөр тасарсан байна.

Аудитаас орлогын төлөвлөгөөг нэр төрөл бүрээр жигд ханган биелүүлэх талаар өмнөх аудитаас зөвлөмж хүргүүлж байсан.

Зөвлөмж

- Орон нутгийн төсвийн орлогын гүйцэтгэлийг нэр төрөл бүр дээр бүрэн биелүүлэх
- Төсвийн тухай хуулийн 41.2 “**Бүх шатны төсвийн захирагч төсвийн хэрэгжилтийн талаар дараах үүрэг хүлээнэ**”, 41.2.1 “**хуулийн дагуу улс, орон нутгийн төсөвт оруулах болон тухайн төсвийн байгууллагын өөрийн үйл ажиллагааны орлогыг бүрэн төвлөрүүлэх**” гэсэн заалтыг дагаж мөрдөх
- Аудитаар өгөгдсөн зөвлөмжийн биелэлтийг ханган ажиллахад онцгой анхаарах

Эрсдэл

- Тайлант онд дэвшүүлсэн зорилго, зорилт хангалтгүй болох

Төсвийн захирагчийн хариу

Хариуцах ажилтан

Архангай аймгийн Аудитын газрын шинжээч...../Ж.Мөнгөншагай/

Булган сумын Төсвийн ерөнхийлөн захирагчийн үүргийг түр орлон гүйцэтгэгч
..... /Г.Ганбаяр/

Санхүүгийн албаны дарга
...../Г.Отгонцэцэг/

5 Аудит хийсэн санхүүгийн нэгтгэсэн тайлан, төсвийн гүйцэтгэл**5.1 Аудит хийсэн санхүүгийн байдлын тайлан**

/ төгрөгөөр /

Код	Үзүүлэлт	Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл
1	ЭРГЭЛТИЙН ХӨРӨНГИЙН ДҮН	573,760,316.21	442,466,397.15
31	МӨНГӨН ХӨРӨНГӨ	254,610,709.65	115,214,050.65
31100	Кассанд байгаа бэлэн мөнгө	0.00	0.00
31200	Банкинд байгаа бэлэн мөнгө	254,610,709.65	115,214,050.65
31210	Төгрөг	254,610,709.65	115,214,050.65
31211	Төрийн сангийн харилцах	252,729,574.65	107,015,215.65
31213	Арилжааны банк дахь харилцах	1,600,000.00	0.00
31214	Бусад төсөл, нөөцийн харилцах	281,135.00	8,198,835.00
32	БОГИНО ХУГАЦААТ ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТ	0.00	0.00
33	АВЛАГА	275,110,595.25	267,246,254.00
33100	Ажиллагчидтай холбогдсон авлага	78,245.25	0.00
33500	Бусад авлага	275,032,350.00	267,246,254.00
33520	Хувь хүмүүсээс авах авлага	275,032,350.00	267,246,254.00
35	БАРАА МАТЕРИАЛ	44,039,011.31	60,006,092.50
35100	Түүхий эд материал	520,797.67	75,664.00
35110	Тусгай зориулалттай материал	44,500.00	0.00
35130	Эм боох материал	476,297.67	75,664.00
35400	Хангамжийн материал	42,770,213.64	43,130,428.50
35420	Аж ахуйн материал	40,859,923.64	41,848,778.00
35440	Түлш, шатах тослох материал	69,230.00	0.00
35460	Хүнсний материал	1,591,060.00	1,281,650.50
35470	Бусад хангамжийн материал	250,000.00	0.00
35600	Мал амьтад	748,000.00	16,800,000.00
2	ЭРГЭЛТИЙН БУС ХӨРӨНГИЙН ДҮН	2,809,944,232.99	2,856,363,401.50
39	ҮНДСЭН ХӨРӨНГӨ	2,809,944,232.99	2,856,363,401.50
39200	Биет хөрөнгө	2,809,811,316.22	2,856,285,484.69
39201	Барилга, байгууламж, орон сууц	3,024,414,308.00	3,107,679,796.00
39202	Хуримтлагдсан элэгдэл	-540,507,872.96	-578,299,129.09
39203	Авто-тээврийн хэрэгсэл	138,292,630.00	163,333,000.00
39204	Хуримтлагдсан элэгдэл	-81,982,143.95	-80,097,930.40
39205	Машин тоног төхөөрөмж(компьютер)	248,412,432.55	283,188,382.55
39206	Хуримтлагдсан элэгдэл	-106,353,981.65	-149,365,502.51
39207	Тавилга, аж ахуйн эд хогшил	172,268,704.55	172,267,203.22
39208	Хуримтлагдсан элэгдэл	-100,146,292.36	-117,363,394.27
39209	Зам, гүүрийн байгууламж	125,930,600.00	121,290,600.00
39210	Хуримтлагдсан элэгдэл	-106,214,692.23	-107,102,975.04
39212	Хуримтлагдсан элэгдэл	0.00	0.00
39213	Түүх соёл, музейн дурсгалт зүйлс	0.00	0.00
39214	Бусад үндсэн хөрөнгө	6,651,717.46	12,359,527.46
39215	Хуримтлагдсан элэгдэл	-2,246,273.59	-2,896,273.63
39217	Ном	31,292,180.40	31,292,180.40
39300	Биет бус хөрөнгө	132,916.77	77,916.81
39301	Програм хангамж	300,300.00	275,000.00
39302	Хуримтлагдсан элэгдэл	-167,383.23	-197,083.19
3	НИЙТ ХӨРӨНГИЙН ДҮН III=I+II	3,383,704,549.20	3,298,829,798.65

4	НИЙТ ӨР ТӨЛБӨР	58,000.00	0.00
41	БОГИНО ХУГАЦААТ ӨР ТӨЛБӨР	58,000.00	0.00
41300	Өглөг	58,000.00	0.00
41360	Бусад өглөг	58,000.00	0.00
41362	Хувь хүмүүст төлөх өглөг	58,000.00	0.00
5	ЦЭВЭР ХӨРӨНГӨ ӨМЧИЙН ДҮН	3,383,646,549.20	3,298,829,798.65
51	Засгийн газрын хувь оролцоо	3,383,646,549.20	3,298,829,798.65
51100	Засгийн газрын оруулсан капитал /Засгийн газрын сан/ орон нутгийн сан	1,163,980,639.41	1,163,980,639.41
51200	Хуримтлагдсан үр дүн	1,963,583,143.13	1,878,848,556.48
51210	Өмнөх үеийн үр дүн	1,854,250,296.90	1,963,665,307.03
51220	Тайлант үеийн үр дүн	109,332,846.23	-84,816,750.55
51300	Хөрөнгийн дахин үнэлгээний зөрүү	256,082,766.66	256,000,602.76
6	ӨР ТӨЛБӨР, ЦЭВЭР ХӨРӨНГӨ ӨМЧИЙН ДҮН VI=IV+V	3,383,704,549.20	3,298,829,798.65

